

*Write your business
success story with
Development Solutions*



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ТАЙЛАН 2018

АГУУЛГА

1. МЭНДЧИЛГЭЭ

2. ТҮҮХЭН ЗАМНАЛ-ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ 10 ЖИЛД

3. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

- Хөгжилд хөтлөх алсын хараа
- Нийгмийн эрхэм зорилго
- Өөрчлөлтийн онол
- Үйл ажиллагааны загвар
- Үнэт зүйлс
- Байгууллагын бүтэц
- Удирдах зөвлөлийн гишүүд
- Байгууллагын хамт олон
- Сайн дурын ажилтнууд
- Сайн дурын менторууд
- Байгууллагын соёл
- Хамтын ажиллагаа

4. БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЧИГЛЭЛҮҮД

5. 2018 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД, ҮР ДҮН

- 2018 оны онцлох ажлууд
- Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд
 - REACH-Жижиг, дунд бизнесийн санхүүжилтийг дэмжих төсөл
 - САНХҮҮГИЙН ЗУУЧЛАЛ, БИЗНЕС ХӨГЖИЛ (FINANCIAL INCLUSION AND BUSINESS DEVELOPMENT) Төсөл
 - Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв
 - YBM-Залуу Бизнесийг Дэмжих Хөтөлбөр
 - Хөгжлийн Шийдэл ТББ-ын Оюу Толгой салбар
 - GYEC- Өсвөрийн Энтрепренёруудын Уралдаан
- БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД

6. САНХҮҮГИЙН БАЙДАЛ

7. АМЖИЛТЫН ТҮҮХҮҮД

8. ГИШҮҮНЧЛЭЛ

9. БИДНИЙ 2019 ОНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

ХАМТЫН АЖИЛЛАГАА

МЭНДЧИЛГЭЭ

Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан 10 жилийн ойн баярын мэндийг Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамт амжилтын түүх бичилцсэн ажилтнууд, сайн дурын ажилтнууд болон хамтрагч байгууллага, иргэд та бүхэнд хүргэе.

Хөгжлийн Шийдэл ТББ нь 2008 онд байгуулагдсан цагаасаа хойш эрхэм зорилгоо биелүүлэхээр тасралтгүй хичээл, зүтгэлтэйгээр ажиллаж байгаа бөгөөд Монгол улсын бизнес эрхлэлт, энтрепренёршипийн хөгжилд олон улсын мэдлэг, туршлагыг түгээн, нутгийн иргэдийн оролцоотой-тогтвортой хөгжлийн шийдлийг бүтээлцсээр байна.

Энэхүү 10 жилийн хугацаанд мэдлэг, ур чадвар, чин сэтгэлээрээ онцгойрох ажилтнууд маань олон улсын стандартаар улс орны орчин, нөхцөлд тохирох 70 гаруй хөтөлбөр, төслүүдийг олон улсын болон дотоодын санхүүжүүлэгч байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн байна. Цаашид энэхүү хүч маань улам нэмэгдэж, илүү ихийг бүтээнэ гэдэгт Гүйцэтгэх Захирлын хувьд бүрэн итгэлтэй байна.

Бидний ажлыг ямагт дэмжин ажилладаг та бүхэнд баярлалаа.

Хүндэтгэсэн,
Гүйцэтгэх Захирал
Э.Бат-Орших

ТҮҮХЭН ЗАМНАЛ ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ

2008-2018

Хөгжлийн Шийдэл ТББ нь 2008 оны 8-р сард үүсгэн байгуулагдсан Монгол улсын төрийн бус байгууллага бөгөөд шинэлэг, үр дүнтэй, шилдэг шийдлээр өрх гэрийн амьдралын чанарыг сайжруулах, өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхыг бий болгох, байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжих чиглэлээр хариуцлагатай, ил тод үйл ажиллагаа явуулдаг.

Манай байгууллага нь үйлчилгээний чанараа тасралтгүй сайжруулсаар 2018 оны 10 сард олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг амжилттай нэвтрүүлсэн.

Түүнчлэн 2008-2018 хооронд дараах үндсэн ажлуудыг гүйцэтгэв.

- ★ 2018 онд Ханбогд сумын малчид болон орон нутгийн захиргаа, Оюутолгой ХХК-ны хамтарсан гурван талт зөвлөлийн гомдол барагдуулах гэрээний хүрээнд хөдөө аж ахуйн стратеги, бодлогын бичиг баримтуудыг боловсруулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх бизнес төслүүдэд хөгжлийн сургалт, зөвлөгөө өгч ажилласан.
- ★ 2016 оноос 2021 он хүртэл Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын захиалга, дэмжлэгтэйгээр Солонгосын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага/KOICA/-ийн санхүүжилттэйгээр Азийн Сангийн хэрэгжүүлж буй “Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв-Инкубатор” төслийн өдөр тутмын үйл ажиллагаа, сургалт, зөвлөгөөг хүргэж байна.
- ★ 2018 онд МерсиКор олон улсын байгууллагатай хамтран махны бизнес эрхлэгчид, малчдын бизнесийг хөгжүүлэх, санхүүжилт зуучлах “Махны нэмүү өртгийн сүлжээнд оролцогчдын санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийг Хэнтий, Сэлэнгэ, Булган, Сүхбаатар аймгуудад хэрэгжүүлэхийн зэрэгцээ малчин залуучуудын гарааны бизнесийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулсан.



- ★ 2016-2018 онуудад Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID) -ийн дэмжлэгтэйгээр Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран жижиг дунд бизнесүүдийг санхүүгийн хувьд илүү бат бөх, тогтвортой үйл ажиллагаатай болоход шаардлагатай санхүүжилтийг



- банк, санхүүгийн байгууллагаас олж авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор REACH(Жижиг, Дунд Бизнес Эрхлэгчдийн Санхүүжилтийг Дэмжих) төслийг Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Сэлэнгэ аймгуудад хэрэгжүүлсэн.
- ★ 2016-2018 онуудад Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний Газартай хамтран орон нутгийн малчид, МСҮТ төгсөгчдөд бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх аж ахуй эрхлэлтийн цогц сургалтуудыг зохион байгуулсан.
 - ★ 2017-2018 онуудад Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилттэй Залуучуудын Хөдөлмөр Эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд Орон Нутгийн ментор зөвлөхүүдийг бэлтгэн орон нутгийн гарааны бизнес эрхлэгч залуучуудыг дэмжиж ажилласан.
 - ★ 2016-2018 онуудад Global Youth Entrepreneurship Challenge олон улсын тэмцээнийг Япон улсын Хүүхдийг Ивээх сантай хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд сурагчдад техник, технологийн чиглэлээр бизнесийн төсөл боловсруулах, бизнес санаа гаргах, танилцуулах сургалт хийж олон улсын тэмцээнд амжилттай оролцуулж байна.
 - ★ 2013 оноос эхэлсэн АНУ-д төвтэй Global Communities олон улсын байгууллагын Сэлэнгэ, Төв, Хэнтий, Хөвсгөл, Дархан-Уул аймгууд дахь хөдөө аж ахуйн хоршоодын бизнесийг хөгжүүлэх, зах зээлтэй холбох, санхүүжилт олгох үйл ажиллагаанд хамтран ажилласан.

- ★ 2015-2016 онуудад Монгол Улсын Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам, Дэлхийн банкны санхүүжилтээр орон нутгийн малчдад хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг нэмүү өртөг шингээн зах зээлд холбох “Хөдөө Аж Ахуйн Маркетинг” төслийн Мэргэжлийн Зөвлөх Үйлчилгээний багаар Баянхонгор аймгийн Жаргалант, Галуут, Баянцагаан сумуудад хэрэгжүүлсэн.
- ★ 2012-2018 онуудад Швейцарын Хөгжлийн Агентлагийн Тогтвортой Бичил Уурхай төсөлтэй хамтран малгүй болсны улмаас бичил уурхай эрхэлж буй орон нутгийн иргэдийн бизнес эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг Баянхонгор, Дорноговь, Төв, Архангай, Говь-Алтай, Сэлэнгэ, Дундговь, Баян-Өлгий, Ховд, Хэнтий, Өмнөговь, Завхан, Увс аймгуудад хэрэгжүүлсэн.
- ★ 2010 онд Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Бизнесийн Зөвлөх Үйлчилгээ – Монгол хөтөлбөр болон Энержи Ресурс ХХК-ийн дэмжлэгтэйгээр Өмнөговь аймгийн бичил, жижиг бизнесийг хөгжүүлэх “Жижиг дунд бизнесийг чадавхжуулах, уул уурхайн хангамжийн үйлчилгээг нэвтрүүлэх” хөтөлбөрийг Өмнөговь аймгийн Цогтцэций суманд хэрэгжүүлж, орон нутгийн анхны ханган нийлүүлэгч бизнес эрхлэгчдийг бий болгосон.
- ★ 2011 онд Оюутолгой компанийн санхүүжилтээр Орон нутгийн бизнес, эдийн засгийг дэмжих Говийн Шим хөтөлбөрийг Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Баян-Овоо, Манлай сумуудад хэрэгжүүлж орон нутгийн анхны бизнес эрхлэгчдийг бий болгов.
- ★ 2008-2011 онуудад Монголын Хөдөө Аж Ахуйн Бизнесийг Дэмжих Хөтөлбөрийг АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Яамны санхүүжилтээр Баян-Өлгий, Дархан, Эрдэнэт, Дорнод, Сэлэнгэ, Булган, Төв аймгуудад, Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянгол, Багануур дүүргүүдэд хэрэгжүүлэн малчид, тариаланчид, жижиг дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн.
- ★ 2002 оноос АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Яам, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр, CHF олон улсын байгууллагын Монгол улсад хэрэгжүүлсэн ГЭР Санаачилга, Бизнесийн Хөгжил болон Ажил Эрхлэлтийг Дэмжих Хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын иргэдийн бизнес эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлсэн.

БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

Хөгжлийн Шийдэл ТББ нь шинэлэг, үр дүнтэй, шилдэг шийдлээр өрх гэрүүдийн амьдралын чанарыг сайжруулж, өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхыг бий болгох, байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой нийгэмд үйлчилдэг байгууллага бөгөөд 2008 оны 8-р сарын 14-ны өдөр үүсгэн байгуулагдсанаасаа хойш хэрэгжүүлж буй 70 гаруй төсөл, хөтөлбөрийнхөө хүрээнд харилцагч бүрийнхээ өсөлт, дэвшлийн хөшүүрэг нь болж, иргэд, малчид, бизнес эрхлэгчдийг дэмжих энтрепренёр сэтгэлгээ, хандлага, бизнесийн үр чадвар, борлуулалтын зах зээл, санхүүжилттэй холбох зэрэг олон талын цогц үйлчилгээг үр дүнтэй үзүүлж байна.

ХӨГЖИЛД ХӨТЛӨХ АЛСЫН ХАРАА

Хөгжлийн Шийдэл нь бизнесийн хөгжлийг дэмжих мэргэжлийн цогц үйлчилгээг үзүүлэгч шинэлэг, үр дүнтэй, шилдэг байгууллага байна.

НИЙГМИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Хөгжлийн Шийдэл нь Шинэлэг, Үр дүнтэй, Шилдэг шийдлээр:

- Өрх гэрийн амьдралын чанарыг сайжруулна.
- Өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхыг бий болгоно.
- Байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

ӨӨРЧЛӨЛТИЙН ОНОЛ

Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч болох малчид, жижиг, дунд бизнес эрхлэгчид, энтрепренёрууд болон хүүхэд, залуус, эмэгтэйчүүдэд хүн төрөлхтөн, эх дэлхийдээ ээлтэй үр ашиг өндөртэй бизнесийг эрхлэх аргачлал, мэдлэг, мэдээлэл, түршлагыг түгээвэл иргэдийн амьдралын чанар болон бизнесийн өрсөлдөхүйц, тогтвортой өсөлтийг хангах хөгжлийн шийдэлд хүрнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАГВАР

Хөгжлийн Шийдэл ТББ нь Монгол улсын хувийн хэвшлийн хөгжлийг хурдасгах хүрээнд дотоод, гадаадын санхүүжүүлэгч, дэмжигч байгууллагуудтай хамтран ажиллаж дэлхийн мэдлэг, түршлагыг чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартын дагуу эх орондоо суурьшуулан бизнесийн шинэлэг, үр дүнтэй, шилдэг амжилтын түүхүүдийг бичилцэнэ.


ҮНЭТ ЗҮЙЛС

Хөгжлийн Шийдэл нь алсын хараатай, ашгийн бүс, бие даасан Монголын төрийн бүс байгууллага юм.

Хөгжлийн Шийдэл нь харилцагч нэг бүрийн хэрэгцээнд тохирсон үнэ цэнэтэй, үр дүнд чиглэсэн бизнес хөгжлийн урт хугацааны цогц шийдлийг өргөн хүрээгээр үзүүлдэг.

Манай байгууллагын ажилтан бүр үр дүнтэй хамтын ажиллагааг эрхэмлэдэг бөгөөд дэлхийд танигдсан бизнесийн хөгжлийн арга, түршлагаар Монголын бичил болон жижиг, дунд бизнесийн чадавхыг хөгжүүлэх үр чадвартай.

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ



УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Удирдах зөвлөлийн дарга:
Бүдрагчаагийн БАЯР

Удирдах зөвлөлийн гишүүн:
Цэрэнбямбаагийн БАТХҮҮ

Удирдах зөвлөлийн гишүүн:
Мандахын ЦЭНДЖАВ

Удирдах зөвлөлийн гишүүн:
Хүрэлбаатарын БААСАНЖАРГАЛ

Удирдах зөвлөлийн гишүүн:
Гүмэнжавын ЦЭВЭГЖАВ

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ

БАЙГУУЛЛАГЫН ХАМТ ОЛОН

Одоогийн байдлаар 22 үндсэн ажилтантай. Нийт ажилтнуудын 90 хувь нь зөвлөх, сургагч багш бөгөөд бизнес хөгжлийг дэмжих мэргэжлийн цогц үйлчилгээг хүргэхээр зорин ажиллаж байгаа.

САЙН ДУРЫН АЖИЛТНУУД

Хөгжлийн Шийдэл ТББ нь байгуулагдсан цагаас хойш АНУ, Япон, Канад болон Их Британи зэрэг улс орнуудаас нийт 16 сайн дурын ажилтнуудтай хамтран ажиллаад байна. 2018 онд 3 орны олон улсын сайн дурын ажилтнууд байгууллагын үйл ажиллагааг дэмжин ажиллахын зэрэгцээ бизнес эрхлэгч харилцагчдад өөрсдийн мэдлэг, туршлагаа хуваалцлаа.

САЙН ДУРЫН МЕНТОРУУД

Хөгжлийн Шийдэл ТББ нь сайн дурын 200 гаруй бизнес менторуудыг Улаанбаатар хот болон орон нутгуудад бэлтгэн зорилтот бүлгийн бизнес эрхлэгчид, энтрепренёруудад зөвлөгөө өгч байна.

БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ

Хөгжлийн Шийдэл ТББ нь анх байгуулагдсан цагаас эхлэн өөрийн гэсэн соёлыг бий болгон төлөвшүүлж, ажилтан бүр байгууллагын үнэт зүйлсийн нэг бөгөөд байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, зорилтуудыг биелэхэд чухал үүрэгтэй.

Хөгжлийн Шийдэл ТББ нь ажилтнуудаа өсөн дэвших, өөрөө өөрийгөө хөгжүүлэх боломжоор хангаж, эрч хүчээр дүүрэн, тав тухтай орчныг бүрдүүлэн ажиллах нөхцөлийг бий болгож чадсанаар ажилтан бүр өөрийн ажил мэргэжил, үүрэг хариуцлагын хүрээнд үр бүтээлтэй, сэтгэл хангалуун, халуун дулаан уур амьсгалтай нэгэн хамт олныг бий болгож Хөгжлийн Шийдэл хэмээх байгууллагын амжилтын түүхийг хамтдаа бичилцэж байна.

Байгууллагын ажилтнуудын 98% нь их, дээд боловсрол эзэмшсэн, дотоод, гадаадын мэргэжлийн болон үр чадварын сургалт, хөтөлбөрт хамрагдсан бөгөөд захиалагч, санхүүжүүлэгч байгууллагууд мөн үр шим хүртэгч бизнес эрхлэгчидтэй ажиллахад чадварлаг, хичээнгүй, ёс зүйг эрхэмлэсэн, ялангуяа шударга, ил тод, зарчимч, хариуцлагатай, нөхөрсөг байдлаараа орчин үеийн байгууллагын соёлыг бүрдүүлсэн бусад байгууллагууддаа үлгэр жишээ болгон харуулж чадсан эрч хүчтэй залуу хамт олон юм.

Хэрэгжүүлж байсан төсөл хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн орон нутагт салбар байгуулан доод тал нь 2-5 ажилтнуудтай байсан ба үүнээс үүдэн монгол орон даяар аймаг, сумуудад бизнесийн зөвлөхүүдийн сүлжээг бий болгон.

ХАМТЫН АЖИЛЛАГАА



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХӨТЛӨХ 17 ЗОРИЛГО 2016-2030

НҮҮР ХҮҮДАС

ТХЗ 17 ЗОРИЛГО

ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТООЦООЛОЛ

МУ-ЫН ТХҮБ-2030

НОГООН ХӨГЖИЛ



Бидний үйл ажиллагааны үндсэн зарчим НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилгуудын хүрээнд явагддаг. "Тогтвортой хөгжлийн зорилгууд" бол хүн төрөлхтний 2030 он гэхэд хийж гүйцэтгэх ёстой "гэрийн даалгавар" тул энэ их үйлийн хэрэгжилтэд зөвхөн төр засгийн хариуцлага биш хувь хүмүүсээс эхлээд иргэний нийгэм, олон нийтийн байгууллагууд, хувийн хэвшил бүгдийн оролцоо ижил түвшинд шаардлагатай. Бид хийж бүтээж буй үнэт зүйлс, үйл ажиллагааныхаа үр дүнд энэхүү 17 зорилгын биелэлтэд хувь нэмэр оруулж байгааг доорх хэдэн жишээгээр илэрхийлж болно.

ХАМТЫН АЖИЛЛАГАА



ЗОРИЛГО 5:

Жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилгын хүрээнд:

Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүд Төв төслийн хүрээнд өнгөрсөн 2,5 жилийн хугацаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн 3000 гаруй эмэгтэй төвөөр зочилж, сургалт семинарт оролцож өөрийн бизнес санааг хэрэгжүүлж нийгэм дэх байр сууриа бэхжүүлж чадсан байна. Мөн түүнчлэн REACH Төслийн нийт үйл ажиллагаанд хамрагдагсдын 60% нь эмэгтэйчүүд буюу санхүүжилтэд хамрагдаж бизнесээ өргөжүүлсэн эмэгтэй бизнес эрхлэгчид 40%-ыг эзэлж байна.



ЗОРИЛГО 8:

Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох зорилгын хүрээнд:

Хөгжлийн Шийдэл ТББ нь Монгол улсын эдийн засгийн хөшүүрэг болсон жижиг, дунд бизнесүүдэд нэн шаардлагатай бизнесийн зөвлөх үйлчилгээ, бизнесийн сургалтууд, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн үр дүнд бизнесээ өргөжүүлэх 39,6 сая \$-ын санхүүжилтийг зүүчилж, борлуулалтын орлогыг 2,4сая \$-аар өсгөсөн байна. Түүнчлэн 19,500 гаруй шинээр ажлын байрыг бий болгосон байна.



ЗОРИЛГО 9:

Инноваци болон дэд бүтцийн нэмэгдүүлэх зорилгын хүрээнд:

Social Entrepreneur Mongolia, Youth Business Mongolia хөтөлбөрүүдийн хүрээнд зохион байгуулагддаг үйл ажиллагаанууд инновацилаг шинэ бизнес санаануудыг илрүүлж, тэдгээрийн хэрэгжилтэд шаардлагатай хамтрагч талуудын оролцоотойгоор зохион байгуулдгаараа онцлогтой.



ЗОРИЛГО 17:

Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зорилгын хүрээнд:

Бидний явуулж буй бизнесийн хөгжлийн төлөөх үйл ажиллагааны хүрээнд талууд болох төр засаг, дотоод гадаадын хандивлагч ОУ-ын байгууллагууд, банк санхүү, иргэний нийгмийн, ТББ-ууд, хувийн хэвшлийн хооронд гүүр нь болж түншлэлийн хүрээг тэлсэн томоохон форум, семинаруудыг зохион байгуулж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЧИГЛЭЛҮҮД

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчид өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад бизнесээ удирдах зөв чиглүүлэх зөвлөгөө, сургалт, санхүүжилт олж авах арга хэрэгсэл, бизнес хийх энтрэпренёр сэтгэлгээ, хандлага хөгжүүлэх болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээгээ амжилттай борлуулах арга барил, борлуулалтын сувгуудтай холбогдох зайлшгүй хэрэгцээ шаардлагатай тулгардаг. Харин Хөгжлийн Шийдэл ТББ нь зах зээлийн эдгээр хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн бизнесийн зөвлөх үйлчилгээ, бизнесийн сургалт болон гадаад дотоодын донор байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж Монголын аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч, малчдад бизнес хөгжлийн арвин их туршлагаараа үйл ажиллагаагаа тасралтгүй хүргэж байна.

БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

- Ү YBM-Залуу Бизнесийг Дэмжих Санаачилга
- Ү REACH-Жижиг, Дунд Бизнесийн Санхүүжилтийг Дэмжих Төсөл
- Ү Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв
- Ү Бизнесийн Холболтын Хөтөлбөр
- Ү Жижиг, Дунд Бизнесийг Дэмжих Төв
- Ү Бүлэг, Хоршооны Засаглалыг Дэмжих Хөтөлбөр
- Ү Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Хувийн Бирж
- Ү Ментор Хөтөлбөр



БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТ

- Ү Гайхалтай үйлчилгээ
- Ү Шилдэг ажилтан
- Ү Ажилтнаа тогтоон барих аргууд
- Ү Борлуулалтыг өсгөх сэтгэлгээний өөрчлөлт
- Ү Мэдээлэл солилцооны үнэ цэнэ
- Ү ТББ-ын менежмент
- Ү Бизнесийн бүлэг, хоршоодын менежмент



БИЗНЕСИЙН ЗӨВЛӨГӨӨ, ҮЙЛЧИЛГЭЭ

- Ү Бизнесийн үнэлгээ, судалгаа
- Ү Стратегийн удирдлага
- Ү Маркетингийн удирдлага
- Ү Зах зээлийн судалгаа
- Ү Хүний нөөцийн удирдлага
- Ү Менежмент
- Ү Санхүү, нягтлан бодох бүртгэл
- Ү Зээлийн зуучлал
- Ү Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих загварчлал



СУРГАЛТ, СЕМИНАР

- Ү Бизнесийн сургалт
- Ү Зөв эхлэл, цогц мэдлэг
- Ү Зээлдэгчийн боловсрол
- Ү Анхан шатны нягтлан бодох бүртгэл
- Ү Санхүүгийн тайлан бэлдэх, унших
- Ү Бизнесийн төсөл, төлөвлөгөө боловсруулах
- Ү Өрхийн төсөв
- Ү Хүүхдийн санхүүгийн боловсрол

2018 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД, ҮР ДҮН

ОНЦЛОХ АЖЛУУД



1-P CAP

"Япон улс руу экспорт хийх арга зам, тавигдах хууль зүйн үндсэн асуудлууд" семинар зохион байгуулагдав.

4-P CAP

REACH Төслийн үр дүнг тайлагнах хаалтын үйл ажиллагаа боллоо.



4-P CAP

Өсвөрийн энтрепренёруудын уралдаан-2018 Тогтвортой Хөгжлийн Зорилтын хүрээнд зохион байгуулагдлаа.

5-P CAP

"ДАСАН ЗОХИЦОХ, ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРТАЙ ОРОН НУТГИЙН ИРГЭД" хөтөлбөрийн хүрээнд Youth Start-up Business уралдааныг Хэнтий, Булган, Сэлэнгэ аймгуудад зохион байгуулагдлаа.





8-Р CAP

Хөгжлийн Шийдэл ТББ-ын Оюу Толгой салбар нээгдлээ.

10-Р CAP

Хөгжлийн Шийдэл ТББ нь чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэв.



10-Р CAP

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн хэрэгжүүлж буй Activated 2030 төслийн хүрээнд “Эрсдэлийг даван туулах чадвар” өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа.

11-Р CAP

Хөгжлийн Шийдэл ТББ нь Мандах Их Сургуультай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа



ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХҮРЭЭНД

REACH-Жижиг, Дунд Бизнесийн
Санхүүжилтийг Дэмжих Төсөл



REACH

Small and Medium Enterprise Access to Credit

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн зүгээс Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран жижиг, дунд бизнесүүдийг санхүүгийн хувьд илүү бат бөх, тогтвортой үйл ажиллагаатай болоход шаардлагатай санхүүжилтийг банк, санхүүгийн байгууллагаас олж авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор REACH төслийг хэрэгжүүлэв.

Энэхүү төслийн зорилго нь олон бэрхшээлүүдээс шалтгаалан банк, санхүүгийн байгууллагаас санхүүжилт авч чаддаггүй жижиг, дунд бизнесүүдэд хэрэгцээтэй зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ авах боломж, чадавхыг нь нэмэгдүүлэхэд оршино.

Төслийн үйл ажиллагаанууд

- Жижиг, дунд бизнесийн санхүүжилтэд хамрагдах үр чадварыг хэрэгцээг тодорхойлох;
- Бизнесийн зээлийн бичиг баримтын бүрдүүлэлтэд дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- Жижиг, дунд бизнесийн санхүүжилтэд төр болон хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох;
- Төслийн 5 салбар нэгжээс зээлийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх;
- “Жижиг, дунд бизнесийн санхүүжилт” форум зохион байгуулах;

Энэхүү REACH Төсөл Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Сэлэнгэ аймгуудад хоёр жилийн хугацаатай хэрэгжиж 2018оны 4 сард хаалтаа хийсэн юм.

Санхүүгийн Зуучлал, Бизнес
хөгжил (Financial Inclusion and
Business Development) төсөл




Хөгжлийн Шийдэл ТББ нь Мерси Кор Монгол (Mercy Corps) олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөрийн хүрээнд Махны нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн хоршоод, малчид, залуусыг санхүүжилттэй холбох бизнесийг дэмжих зорилгоор “Санхүүгийн Зуучлал, Бизнес хөгжил (Financial Inclusion and Business Development)” төслийг хэрэгжүүлж байна.

Энэхүү төслийн хүрээнд Залуучуудын гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн уралдааныг Булган, Хэнтий, Сэлэнгэ аймгуудын мал аж ахуйн салбарын төлөөлөл 18-35 насны 129 залуу энтрепренерүүд 4 долоо хоногийн турш үргэлжилсэн уралдаант шалгаруулалтад оролцож, гарааны хөрөнгийн 5 сая төгрөгийн шагналын эзэн болохын төлөө өрсөлдөв.

Түүнчлэн төслийн хүрээнд “Санхүүжилтийн хүртээмж ба бизнесийн хөгжил” сэдэвт цуврал сургалтуудыг 2018 оны 4-р сараас 2019 оны 1-р сарын хооронд зорилтот Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад зохион байгуулагдав.

Сургалтын хөтөлбөрийн үр дүнд нийт 264 бизнесийг сургалтад хамруулан, 570 сая төгрөгийн зээлд зуучилж, бизнес төлөвлөгөө, менторингийн гэрээ, үйл ажиллагаа сайжруулах төлөвлөгөө гэх төрөл бүрийн бизнес менежментийн арга хэрэгслүүдийг боловсруулахад туслалцаа үзүүлээ.



Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв



БНСУ-ын КОЙКА байгууллагын санхүүжилтээр Азийн сан, Нийслэлийн төр захиргаа, Хөгжлийн Шийдэл ТББ, Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн танхим, Голомт банк болон Голомт Секюритиз ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй гурван жилийн хугацаатай хэрэгжиж буй туршилтын төсөл юм.

Энэхүү төвийн үйл ажиллагаа нь Улаанбаатар хотын эдийн засгийн хөгжилд эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгыг хангах болно. Уг төслийн ач холбогдол нь жендерийн эрх тэгш байдлыг хөхүүлэн дэмжих, ажлын байр шинээр бий болгох, эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, Улаанбаатар хотын Эдийн засгийн хөгжлийн стратегийн хэрэгжилт, тэр дундаа жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд илүү таатай орчин бий болгох зорилгыг дэмжихэд оршино.



Төвөөр үйлчлүүлэгчид:

1786	Бизнесийн ур чадвар олгох сургалт	
644	Бизнесийн зөвлөгөө	
223	Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан	
400	Хамтын оффис	
19	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан	
120	Мэдээллийн үйлчилгээ	
30	Хүүхдийн булан	
694	Менторингийн холболт	
27	Бэлтгэгдсэн ментор	

Youth Business Mongolia Залуу Бизнесийг Дэмжих Хөтөлбөр



Хөгжлийн Шийдэл ТББ нь 2013 онд Лондон хотод төвтэй Youth Business International Олон улсын байгууллагын гишүүнээр элсэн Залуусын Бизнесийг Дэмжих Санаачилга хөтөлбөрийг Монгол улсад хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь 18-35 насны залуусыг нийгмийн энтрепренёр болгон хөгжүүлж бизнес эхлэх болон эрхлэхэд дэмжин ажиллах зорилготой юм.

YBM хөтөлбөрийн зорьж буй үр дүн:

- Ажил хэрэгч нийгмийн энтрепренёр залуус
- Ментортой залуу бизнес эрхлэгчид
- Мэдлэг, туршлага, инноваци, хамтын үнэ цэнэ

YBM хөтөлбөр 2018 онд

1085	575
ЗАЛУУСТ ХҮРЧ	ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН
286	40
ЗАЛУУ БИЗНЕС ӨРГӨЖИН САЙЖИРЧ	БИЗНЕС МЕНТОР БЭЛТГЭЖ
75%	100
3 ЖИЛИЙН ДАРААХ БИЗНЕС ЭРХЛЭЛТ	САНХҮҮЖИЛТ ЗЭЭЛИЙН ХОЛБОЛТ

Хөгжлийн Шийдэл ТББ-ын Оюу Толгой салбар



2018 оны 8 сараас Хөгжлийн Шийдэл ТББ нь Өмнөговь аймгийн Ханбогд суманд өөрийн салбарыг нээж, орон нутгийн малчид, нийгмийн энтрепренёр залуусыг дэмжин ажиллах үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Ханбогд сум нь уул уурхайд түшиглэн эдийн засгийн идэвхт бүс болон хөгжиж буйтай холбоотойгоор энэхүү бүс нутагт хүн амын тоо олшрохын (нэмэгдэхийн) хэрээр жижиг, дунд бизнесийн тоо мөн өссөөр байна.

Хөгжлийн Шийдэл ТББ-ын хувьд энэ бүс нутгийн бизнес эрхлэгчид, малчдын бизнесийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангах бизнесийн зөвлөх үйлчилгээ, бизнесийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх сургалтууд болон бизнесээ өргөжүүлэх санхүүжилт олж авах хэрэгсэлд холбох үйлчилгээгээ үзүүлж эхэллээ. Салбарын үйл ажиллагаа нь төв салбарын үйл ажиллагаатай ижил төстэй бөгөөд олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартын дагуу мэргэшсэн зөвлөх, багш нар дэлхийн бизнесийн хөгжил дэвшлийн чиг хандлагыг бүрэн агуулсан бизнесийн зөвлөхийн үйлчилгээг орон нутгийн бизнес эрхлэгчид, малчдад хүргэн ажиллаж байна.



GYEC- Өсвөрийн Энтерпренёруудын Уралдаан



Global Youth Entrepreneurship Challenge (GYEC) уралдаан нь Японы Center for Entrepreneurship Development болон Индонезийн SURYA Institute-с зохион байгуулдаг олон улсын өсвөрийн энтерпренёруудын үр чадварыг хөгжүүлэх зорилго бүхий уралдаан юм. Энэхүү уралдаанд 2015 оноос Монгол улсаа төлөөлөн Хөгжлийн Шийдэл ТББ нэгдсэн бөгөөд эхний жил ОУ –н шүүгчээр оролцож байсан бол 2016 оноос Хүүхдийг Ивээн Сантай хамтран өсвөрийн энтерпренёруудыг бэлтгэн уг тэмцээнд амжилттай оролцуулж эхэлсэн. 2017 онд Монгол улсаа төлөөлөн анхны багууд олон улсын хэмжээнд өрсөлдсөн.

Зорилго

Энэхүү тэмцээн нь ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагч нарын энтерпренёр сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой.

Хөтөлбөрийн бүтэц

1-р үе шат: Оролцох сургуулиуд багаа бүрдүүлнэ. “Бидний амьдралыг сайжруулах шинэ санаа” 300 үгтэй зохион бичлэгийн уралдаан

2-р үе шат: Шалгарсан 5 баг улсын хэмжээний тэмцээний эцсийн шатанд орох эрх мөн ‘Хүүхдийг Ивээх Сан’ -гийн BEST энтерпренёр сэтгэлгээг хөгжүүлэх сургалтад үнэ төлбөргүй хамрагдах болно.

3-р үе шат: Улаанбаатар хотын хэмжээнд зохион байгуулагдах Өсвөрийн Энтерпренёруудын уралдаанд оролцоно.

4-р үе шат: Шалгарсан баг олон улсын виртуал тэмцээнд өрсөлдөнө.



Хэн оролцдог вэ?

15-18 насны ахлах ангийн 8 ба түүнээс тооны сурагчид сургуулиа төлөөлөн баг болж, өнөөгийн нийгэмд тулгарч буй ямар нэгэн асуудлыг шинэлэг, бүтээлч аргаар шийдсэн инновацилаг бүтээгдэхүүн санаачлан, тухайн бүтээгдэхүүнээ хэрхэн амжилттай бизнес болгох талаар бизнес төлөвлөгөө гарган бүтээлч сэтгэлгээ, үр ухаан, чадвараараа өрсөлддөг.



БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

4,358

ШИНЭ БИЗНЕС

7,618

ӨРГӨЖИН
САЙЖИРСАН БИЗНЕС

20,043

ШИНЭЭР БИЙ БОЛСОН
АЖЛЫН БАЙР

2,2 САЯ \$

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН
ӨСӨЛТ

36,2 САЯ \$

АМЖИЛТТАЙ ЗЭЭЛИЙН
ЗУУЧЛАЛ

8,577

АМЖИЛТТАЙ ЗУУЧИЛСАН
БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТОО

497

БИЗНЕСИЙН БҮЛЭГ ХОРШОО,
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

 60%

ЭМЭГТЭЙ БИЗНЕС
ЭРХЛЭГЧИД

 40%

ЭРЭГТЭЙ БИЗНЕС
ЭРХЛЭГЧИД

 6,560

16-35 НАСНЫ
БИЗНЕС ЭРХЛЭГЧИД

 9,126

16-35 НАСНЫ
СУРГАЛТАД ОРОЛЦОГЧИД

(2018 оны 12 сарын 31-ний байдлаар)

САНХҮҮГИЙН БАЙДАЛ



Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянзүт дүүрэг, Амарсүлэнгийн гудамж-5
Утас: 70005401, 70005404, 70005405
Факс: +976-70005403
Э-Шуудан: info@dalaivanaudit.mn
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Хөгжлийн Шийдэл” ТББ -ын Удирдах Зөвлөлд

Бидний дүгнэлт

Бид 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон баланс, үр дүнгийн тайлан болон цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон гол чухал нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Хөгжлийн Шийдэл” ТББ-ын санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Хөгжлийн Шийдэл” ТББ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн жилийн үр дүн, цэвэр хөрөнгийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Сангийн Яамны 2017 оны 386-р тушаалаар баталсан Төрийн бус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын зааврын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалтай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Хараат бус байдал

Бид Олон Улсын Ёс зүйн Хорооноос гаргасан санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Хөгжлийн Шийдэл ТББ-аас хараат бус байж, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэлд Хөгжлийн Шийдэл ТББ-ын жилийн тайланг хамааруулах бөгөөд үүнд санхүүгийн тайлан болон аудиторын дүгнэлт тайлан багтаагүй.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь Төрийн бус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын зааврын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага, төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоохоос шийдсэнээс бусад тохиолдолд, тасралтгүй байх зарчмын дагуу Хөгжлийн Шийдэл ТББ-ын үйл ажиллагааг зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх үүргийг хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага


Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагналыг байнга илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилантаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ Хөгжлийн Шийдэл ТББ-ын дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Байгууллагын ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв байгууллагын тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд Хөгжлийн Шийдэл ТББ-ын тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Ерөнхий Захирал, МНБ

Ц.Жигдэн



2019 оны 03 дугаар сарын 13

АМЖИЛТЫН ТҮҮХҮҮД



“Хүн хүсээд, хийе, бүтээе гэж зоривол харанхуйд гэрэл түсч байгаа юм шиг л боломжууд гарч ирсээр байдаг.”

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн оршин суугч Э.Болорчимэг нь углаа баривч, гарын бүсийг “ҮНЭГХЭН БРЭНД” нэртэйгээр уламжлалт загварыг орчин үеийн хэрэглээнд нийцүүлсэн дэлхийд танигдсан бүтээгдэхүүн бий болгохоор зорин ажиллаж байна.

Тэрээр Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв төслийн 2018 оны 1 сарын 16 өдөр зохион байгуулагдсан “Онлайн худалдаа” сургалтад хамрагдсанаар онлайн худалдааны мэдээлэл ойлголт, түүний давуу талуудыг ойлгож <https://ardshop.mn/> сайт дээр бараа бүтээгдэхүүнээ байршуулан худалдаа хийж байна. Бараа бүтээгдэхүүн байршуулснаас хойш нийт 5 ширхэг хүүхдийн баривч худалдаалаад байна.

Сонирхлоо ажил хэрэг болгосон бүсгүйн амжилтын түүх

Д.Лхамсүрэн нь өөрийн сонирхолдоо хөтлөгдөн гэрийн эзэгтэйн ажлын хажуугаар гар урлалын схемд ном ашиглан гоёл чимэглэлийн зүйлс урлаж сүрчээ. Өөртөө болон охиндоо гоёл чимэглэлийн зүйлс бага багаар урлан энэ сонирхлоо улам хөгжүүлэн суралцаар Улаанбаатар хотод зохиогдож буй томоохон үзэсгэлэн худалдаануудад өөрийн гараар урласан гоёл чимэглэлээ худалдан борлуулж эхэлсэн байна.



Бүтээгдэхүүнүүдээ худалдан борлуулж эхэлсэн цагаас бизнесээ улам өргөжүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлагатай тулгарч зах зээлийн судалгаа, шинэлэг санааг бизнес хэрхэн болгох талаар эрэлхийлэн явсаар Хөгжлийг Шийдэл ТББ-ын Өглөөний цайн уулзалтуудад идэвхтэй хамрагдаж өөрийн бизнесийн хамтрагч нар болон зөвлөн туслах ментортой болж чадсан байна. Өглөөний эртэч энэхүү уулзалтууд нь түүнд шинэ санаа, шинэлэг зөвлөмжийг олоход илүү дөхөм байж өөрийн сонирхлоор эхлүүлсэн бизнесээ урам зоригтойгоор урагшлахад нь түлхэц болсоор иржээ.

Тэрээр уран дархны сургалтад хамрагдан алт мөнгө үнэт эдлэлийг гараар урлан бизнесийнхээ төрлийг нэмэгдүүлэхээр ажиллаж эхэлсэн бөгөөд хөтөлбөрийн үр дүнд бизнестээ хандах хандлага, хариуцлага илүү өндөр босготой болж борлуулалт, захиалгын тоо өсөн нэмэгдэн улмаар 2018 онд “Индранил МАЛЦ” ХХК-г үүсгэн байгуулж гоёл чимэглэл, гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүнээрээ гадна дотоодын олон үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцсоор байна



Дарханбаатар: Маркетинг, борлуулалтын сувагын талаарх өргөн ойлголт малчид бидэнд нэн чухал байна

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын малчин Дарханбаатар Мерси Кор Олон улсын байгууллагын “Бизнес хөгжил ба санхүүжилтийн хүртээмж” төслийн хүрээнд Сэлэнгэ аймагт зохион

байгуулсан цуврал сургалтуудад бүгдэд нь идэвхтэй хамрагдсан.

Сургалтад хамрагдсан хугацаандаа сонссон зүйлсээ өөрийн амьдралд хэрэгжүүлж өрхийн орлогоо бодитой нэмэгдүүлсэн төдийгүй, цаашдаа бизнесээ өөрчлөх, эргэн тойрны малчидтайгаа хамтран ажиллаж орлогыг нь нэмэгдүүлэх шийдэл, төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Дарханбаатар сургалтын явцад өөрийн сүргийн үхрийг махны ченжүүдээр дамжуулалгүйгээр өөрөө борлуулах боломжтойг ойлгож өөрийн хувийн facebook хаягтаа зар оруулснаар өөрийн зарах ёстой байсан 6 үхрийг зах зээлийн үнээр, дундын зуучлагчгүйгээр борлуулж нэг үхрээс 200-300 мянган төгрөгийн нэмэлт орлого олж чадсан.

Сургалтын явцад зөвхөн мах зарах биш, харин үнэ цэнэ, үйлчилгээ шингээж зарах ёстой гэсэн санааг маш сайн хэрэгжүүлж, хэрэглэгчдэд өвлийн идэшний үхрийг жижиглээд тогоонд багтахар болгоод гэрт чинь хүргэж өгнө гэсэн маш оновчтой маркетинг, маш оновчтой бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үнэ цэнэ санал болгож чадсан байна.

Г.Дүүрэнбилэг: “Бид өөрсдийн мал аж ахуйдаа хэрэглэдэг хуучны арга техникээ сайжруулж чадвал бүтээмжээ дээшлүүлж чадна. Залуучууд бидэнд бүхий л боломж бий шүү”

Хэнтий аймгийн Хэрлэн суманд дүүгийн хамт үхрийн эрчимжсэн мал аж эрхэлдэг 26 настай залуу бизнес эрхлэгч маань их сургуулиа дүүргэсний дараагаар хөдөө гарч мал аж ахуй эрхлэхээр анх шийдэхэд нь үеийн найзууд болон дотнын хүмүүс ихэд гайхан хүлээж авч, эсэргүүцэж байжээ.

Тэрээр анх бизнесээ эрхлэх санаагаа олчихсон боловч санхүүжилт хэрхэн авахаа мэдэхгүй явахдаа Хөгжлийн Шийдэл ТББ Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газартай хамтран Залуучуудын гарааны бизнесийг дэмжих



- Үйл ажил**
- 150 голтой үхэр
 - 80 хээлэгч үхэр
 - 24-36 сартай огов тээлд нийлүүлдэг
 - МАА-н тоног төх

уралдаанд оролцон хүүгүй 10 сая төгрөгийн зээл авч бизнесээ эхлүүлж чадсан юм.

Одоо тэрээр үхрийн эрчимжсэн мал аж ахуйгаас гадна малын тэжээл тариалж, мал аж ахуйд хэрэгтэй тоног төхөөрөмжүүдийг үйл ажиллагаагаа хялбар болгож, бүтээмжээ нэмэгдүүлэх зорилгоор бие даан үйлдвэрлэж эхэлсэн нь нэлээд амжилттай болж анхны захиалгуудаа аваад байгаа ажээ. Эрч хүчтэй залуу бизнес эрхлэгч маань Бид өөрсдийн мал аж ахуйдаа хэрэглэдэг хуучны арга техникээ сайжруулж чадвал бүтээмжээ дээшлүүлж чадна. Залуучууд бидэнд бүхий л боломж бий шүү” хэмээн хэлж байлаа.

Дээд боловсролтой малчдын эрин үеийн төлөөлөл Дарханбаатар

Австри улсад мэргэжил дээшлүүлээд эх орондоо буцаж ирээд гэр бүлийн хамт эрчимжсэн мал аж ахуй эрхлэхээр зоригтой шийдсэн залуу бизнес эрхлэгч Дарханбаатар маань манай улсын дээд боловсролтой малчдын эрин үеийн төлөөлөл

юм. Бидний эрхэлдэг мал аж ахуйг улам боловсронгуй болгон, монгол махыг дэлхийн брэнд болгох зорилготой тэрээр бизнесээ амжилттай эхэлсэн боловч тогтвортой үйл ажиллагаа эрхлэх мэдлэг, нөөц бололцоо дутмаг байжээ.

Тэрээр манай байгууллага Мерси Кор ОУ-н байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Санхүүгийн Хүртээмж ба Бизнесийн Хөгжил” хөтөлбөрт хамрагдан бизнесээ сайжруулах мэдлэг мэдээлэл олж авч, маркетингаа сайжруулан бүтээгдэхүүнээ амжилттай худалдаалж мөн бизнес төслөө бичүүлэн авч Хаан банкнаас 10 сая төгрөгийн Бизнесийн зээл авч чадсан юм.

“Мал аж ахуй бол манай улсын шавхагдашгүй маш чухал баялаг. Малчид бол ирээдүйтэй томоохон бизнес эрхлэгчид. Олон олон залуучуудад үүнийг ойлгуулж, өөрийн биеэр үлгэр жишээ болохыг хүсдэг” гэж залуу малчин маань хэлж байсан юм



ГИШҮҮНЧЛЭЛ

Хөгжлийн Шийдэл ТББ нь бизнес эрхлэлтийг дэмждэг дотоодын болон олон улсын сүлжээ байгууллагуудын гишүүн юм. Уг сүлжээ байгууллагуудын гишүүнчлэлд хамрагдсанаар Монгол улсад олон улсын жишиг хөтөлбөрүүдийг суурьшуулах, нөгөөтээгүүр Монголын түршлагыг олон улсад хуваалцан харилцан ашигтай санал солилцох боломжтой байдаг. Мөн дэлхийн хөгжил дэвшлийг Монголын бизнес эрхлэгчдэд таниулан олон улсын менежментийн арга барилыг сурган дэлхийд өрсөлдөх бизнесүүдийг бий болгоход чиглэдэг.




Даян дэлхийн нийгмийн энтрепренёруудын
сүлжээний гишүүн / Global Social Entrepreneurship Network/

Даян Дэлхийн Нийгмийн Энтрепренёруудын Сүлжээ байгууллага эх дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгуудыг бизнес эрхлэлттэй уялдуулан биелүүлэхийн төлөө ажиллаж байна. 2017 онд тус байгууллага нь нийт 55 гишүүнтэй байсан бөгөөд Хөгжлийн Шийдэл ТББ нь өөрийн эрхэм зорилгын хүрээнд 55 дахь гишүүнээр элссэн. Өнөө цагт бизнесийг зөвхөн мөнгөн ашгийн зорилгоор бус нийгмийн асуудлыг шийдэх замаар тогтвортой бизнес загвараар удирдан явуулах үр чадварыг энэхүү сүлжээ байгууллагаар дамжуулан түгээн дэлгэрүүлж байна.



Youth Business International
Олон улсын байгууллагын гишүүн

Залуусын Бизнесийг Дэмжих Санаачилга Сүлжээ байгууллага нь дэлхийн 50 гаруй орныг эгнээндээ нэгтгэсэн ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг юм. Анх ИБУИВУ-ын Уэльсийн хунтайж Чарльзийн санаачилгаар залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэж байсан бөгөөд өдгөө залуучуудыг зөвхөн ажил хайгч бус ажил олгогч болгон бэлтгэхэд менторинг, санхүүжилт болон энтрепренёршипийн сургалтын хөгжлийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж 2025 он гэхэд дэлхийн нэг сая залуусыг ажлын байртай болгох зорилт тавин ажиллаж байна. Хөгжлийн Шийдэл ТББ нь 2013 оноос хойш тус байгууллагын итгэмжлэгдсэн гишүүн юм.





Frontier Innovators
олон улсын санаачилгын Монгол дахь төлөөлөгч

Frontier Innovators олон улсын санаачилга нь Австралийн засгийн газрын Ази, Номхон далайн бүс нутагт нийгмийн нөлөөллийг өргөжүүлэхэд чиглэсэн нийгмийн энтрепренёруудыг дэмжих зорилготой дөрвөн хөтөлбөрийн нэг юм. Хөгжлийн Шийдэл ТББ-ын хувьд 2017 оноос тус хөтөлбөрийн Монгол дахь төлөөлөгч юм.



WANGO
Олон Улсын Төрийн Бус Байгууллагуудын Сүлжээ

WANGO- Олон Улсын Төрийн Бус Байгууллагуудын Сүлжээ нь төрийн бус салбарыг бүхэлд нь бэхжүүлэх, урамшуулах, төрийн бус байгууллагуудын олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, шаардлагатай механизм, дэмжлэг үзүүлэх, гишүүн байгууллагууддаа үйлчилдэг олон улсын байгууллага юм. ТББ-ууд нь хүн төрөлхтний үндсэн асуудлыг шийдвэрлэхэд оруулсан хувь нэмрийг нь бусадтай холбох, түншлэл бий болгох, туршлага мэдээлэл хуваалцах, тэдэнд урам зориг өгөх, олшруулан түгээх зорилготой. Хөгжлийн Шийдэл ТББ-ын ХХХ оноос хойш уг ОУБ-ын гишүүн юм.



Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Институт

Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Институт нь Монгол улсын мэргэшсэн зөвлөхүүдийг эгнээндээ нэгтгэсэн, Олон Улсын Мэргэшсэн Менежментийн Зөвлөхүүдийн Институтийн гишүүн байгууллага юм. Хөгжлийн Шийдэл ТББ нь 2011 онд гишүүнээр элсэж харилцагчдадаа үзүүлж буй сургалт, зөвлөгөөний үйлчилгээг олон улсын зөвлөх үйлчилгээний стандартад нийцүүлэхийн зэрэгцээ тус институтийн дэмжлэгтэйгээр багш, зөвлөхүүдээ ямагт хөгжүүлдэг.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

